



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Бөхчулууны ПҮРЭВДОРЖ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-30-34, Факс: 26-30-34
E-mail: purevdorj@parliament.mn
<http://www.parliament.mn>

2022.04.29 № УИХ-05/3363

танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг санаачлан боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Б.ПҮРЭВДОРЖ

С.ОДОНТУЯА

Б.БЕЙСЕН



УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Бөхчулууны ПҮРЭВДОРЖ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-30-34, Факс: 26-30-34
E-mail: purevdorj@parliament.mn
http://www.parliament.mn


2004.03.25 № МУХ-03/1428
танай _____-ны № _____-т

Тов тогтоолгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулсаныг хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хавсралт 25 хуудастай

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Б.ПҮРЭВДОРЖ
С.ОДОНТУЯА
Б.БЕЙСЕН

000197



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2001 он 02 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 2001/447

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Б.ПҮРЭВДОРЖ
ТАНАА

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг үүгээр хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны 9 дүгээр тэмдэглэлд:

“Ү.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн санаачлан боловсруулсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн санаачлан боловсруулсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд дараахь үндэслэлээр дэмжих боломжгүй гэсэн саналыг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:


1. Монгол Улсын Засгийн газар Олон улсын валютын сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т хамрагдсантай холбогдуулан 2018 онд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх аль дуртай дараалсан 7 жилд төлсөн шимтгэлээс тооцож гаргасан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос бодож, тэтгэврийн хэмжээг тогтоохоор хуульчилсан.

Энэхүү арга хэмжээ нь Олон улсын валютын сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т хамрагдах шаардлагын нэг байсан учраас тэтгэвэрт гарах хугацаа ойртсон даатгуулагчдын хувьд хүндрэлтэй тусахаар богино хугацаанд хэрэгжсэн тул Монгол Улсын Засгийн газраас даатгуулагчдад үүсэх хүндрэлийг бууруулах зорилгоор хүн амын амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан 2018, 2019, 2020 онуудад нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг жилд дунджаар 8 орчим хувиар нэмэгдүүлсэн. Ингэснээр тэтгэврийн хэмжээ 2016 онтой харьцуулахад 30.0 орчим хувиар нэмэгдээд байна.

2. Улсын Их Хурлын 2015 оны 53 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-ын 3.2.8-д “1979 оноос өмнө төрсөн даатгуулагчийн тэтгэвэр тогтооход баримтлах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын даатгуулагчийн 5 жилийн цалин хөлсний дунджаар тодорхойлж байгааг 2020 оноос нэмэгдүүлж, 2025 он гэхэд даатгуулагчийн 10 жилийн цалин хөлсний дунджийг үндэслэн тодорхойлдог болох бөгөөд цаашид даатгуулагчийн шимтгэл төлсөн нийт хугацааны цалин хөлсний дунджийг үндэслэн тэтгэврийг тогтоох” үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр заасан.

Мөн шимтгэл төлсөн 5 жилийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас тэтгэвэр бодож тогтоох нь даатгуулагчдад шударга бус, харилцан адилгүй тэтгэвэр тогтоогдох нөхцөлийг бүрдүүлж байсан. Тухайлбал, сайн дураар даатгуулагч нь олон жил бага шимтгэл төлж сүүлийн таван жилийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоо өндрөөр мэдүүлж, өндөр тэтгэвэр тогтоолгох

тохиолдол гарч байна. Өөрөөр хэлбэл, хуулийн төсөл нь даатгуулагч, тэтгэвэр авагчдад шударга байх зарчим, “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-той нийцэхгүй байна.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**БАТЛАВ.
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**



Б.ПҮРЭВДОРЖ

С.ОДОНТУЯА

Б.БЕЙСЕН

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын төрөөс хүн амын нийгмийн хамгааллыг сайжруулах бодлогыг тодорхойлж нийгмийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгон улс орныхоо онцлогт нийцсэн тэтгэврийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2015-2030 онд баримтлах үндсэн чиглэлд “2.1.1.Монгол Улсын ахмад настан бүр орлогын наад захын баталгаат тэтгэврээр хангагдах;”, “3.2.16.тэтгэврийн хэмжээг жил бүрийн үнийн өсөлт болон дундаж цалин хөлсний өсөлттэй уялдуулан нэмэгдүүлж, шаардагдах хөрөнгийг төсөвт тусгаж байх;”-аар, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.5-д “Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг инфляц, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ” гэж тус тус заасан.

2018 оны 2 дугаар сарын 2-ны өдөр Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулахдаа өндөр насны тэтгэврийг дараалсан 7 жилийн буюу 84 сарын дундаж цалингаар тогтоохоор өөрчилсөн. Энэхүү өөрчлөлтөө тайлбарлахдаа ийнхүү 7 жилийн дунджаас тэтгэврийн дунджийг бодож тогтоовол өндөр тогтоно, олон жил шимтгэл төлснөөр авах тэтгэврийн хэмжээ нь нэмэгдэнэ гэж буруу тайлбарлаж байна.

Хүний амьдралд өөрөөс нь хамаарахгүйгээр өвдөх, осолдох, эндэх гэх зэрэг олон эрсдэл тохиолддог. Иргэдийн амьдралд тохиолдох эрсдэлүүд хэзээ, хэдийд тохиолдохыг хэн ч урьдчилан тааж мэдэх боломжгүй юм. Тэгэхээр нийгмийн даатгалд даатгуулснаар өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, ажилгүй болох, өвчлөх, үйлдвэрлэлийн осолд өртөх зэрэг урьдчилан таах боломжгүй эрсдэлийн улмаас орлого олох чадвар буурах, орлогогүй болох үедээ тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрхтэй болдог.

Өнөөдөр манай улсад дунджаар 317 мянга орчим нь өндөр насны тэтгэвэр авагч байдаг. 2017 онд тэтгэврийн насыг нэмэгдүүлсэн, 2018 онд өндөр насны тэтгэвэр тогтоохдоо нийгмийн даатгалын шимтгэл тасралтгүй төлсөн 5 жилийн буюу 60 сарын дундаж цалингаар тогтоодог байсныг нэмэгдүүлж 7 жил буюу 84 сар болгосон нь иргэдийн гар дээр ирэх тэтгэврийн дүн багасаж байгаа юм.

Иргэдэд олгож байгаа тэтгэвэр нь тухайн даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацаа болон шимтгэл төлсөн дундаж цалин хөлснөөс шууд хамааралтайгаар бодогддог.

Хоёр. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл тэтгэвэр тогтоолгох хөдөлмөрийн хөлсийг даатгуулагч тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх аль дуртай дараалсан 5 жилд төлсөн шимтгэлээс тооцож гаргасан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос бодож тодорхойлох зорилготой.

Гурав. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагаврын талаар

Иргэдийн өндөр насны тэтгэврийн гар дээр авах мөнгө дүн бодитоор нэмэгдэнэ. Иргэд өөрсдийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэлээс өндөр насны тэтгэврээ авч байгаа учир улсад төсөв, эдийн засгийн эрсдэл, хүндрэл учрахгүй.

Дөрөв. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсантай холбогдуулан нэмэлт, өөрчлөлт орох хуулиуд

Хуулийн төсөл Үндсэн хууль болон бусад хуульд нийцэж байгаа бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт орохгүй, дагалдан хууль батлахгүй.

--- оОо ---

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын төрөөс хүн амын нийгмийн хамгааллыг сайжруулах бодлогыг тодорхойлж нийгмийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгон улс орныхоо онцлогт нийцсэн тэтгэврийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2015-2030 онд баримтлах үндсэн чиглэлд “2.1.1.Монгол Улсын ахмад настан бүр орлогын наад захын баталгаат тэтгэврээр хангагдах;”, “3.2.16.тэтгэврийн хэмжээг жил бүрийн үнийн өсөлт болон дундаж цалин хөлсний өсөлттэй уялдуулан нэмэгдүүлж, шаардагдах хөрөнгийг төсөвт тусгаж байх;”-аар, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.5-д “Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг инфляц, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ” гэж тус тус заасан.

2018 оны 2 дугаар сарын 2-ны өдөр Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулахдаа өндөр насны тэтгэврийг дараалсан 7 жилийн буюу 84 сарын дундаж цалингаар тогтоохоор өөрчилсөн. Энэхүү өөрчлөлтөө тайлбарлахдаа ийнхүү 7 жилийн дунджаас тэтгэврийн дунджийг бодож тогтоовол өндөр тогтоно, олон жил шимтгэл төлснөөр авах тэтгэврийн хэмжээ нь нэмэгдэнэ гэж буруу тайлбарлаж байна. Яагаад буруу гэдгийг бодит жишээгээр харуулая. Нэг иргэний цалингаар тооцож үзүүлье.

Нэрийн дансанд тооцсон өгөөжөөр өсөлтийг тооцсон байдал				
он	Жил	Цалингийн өсөлт *	Сарын дундаж цалин	
2000	1	13.0%	150,000	150,000
2001	2	14.0%		171,000
2002	3	14.0%		194,940
2003	4	5.0%		204,687
2004	5	11.0%		227,203
2005	6	7.0%		243,107
2006	7	11.1%		270,092
2007	8	15.8%		312,766
2008	9	18.7%		371,253
2009	10	29.8%		481,887
2010	11	28.3%		618,261
2011	12	25.4%		775,299
2012	13	20.6%		935,011
2013	14	22.3%		1,143,518
2014	15	18.6%		1,356,212
2015	16	10.2%		1,494,546
2016	17	7.9%		1,612,615
2017	18	6.7%		1,720,660
2018	19	5.0%		1,806,693
2019	20	5.0%		1,897,028
2020	21	5.0%		1,991,879

Хүний амьдралд өөрөөс нь хамаарахгүйгээр өвдөх, осолдох, эндэх гэх зэрэг олон эрсдэл тохиолддог. Иргэдийн амьдралд тохиолдох эрсдэлүүд хэзээ, хэдийд тохиолдохыг хэн ч урьдчилан тааж мэдэх боломжгүй юм. Тэгэхээр нийгмийн даатгалд даатгуулснаар өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, ажилгүй болох, өвчлөх, үйлдвэрлэлийн осолд өртөх зэрэг урьдчилан таах боломжгүй эрсдэлийн улмаас орлого олох чадвар буурах, орлогогүй болох үедээ тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрхтэй болдог.

Өнөөдөр манай улсад дунджаар 317 мянга орчим нь өндөр насны тэтгэвэр авагч байдаг. 2017 онд тэтгэврийн насыг нэмэгдүүлсэн, 2018 онд өндөр насны тэтгэвэр тогтоохдоо нийгмийн даатгалын шимтгэл тасралтгүй төлсөн 5 жилийн буюу 60 сарын дундаж цалингаар тогтоодог байсныг нэмэгдүүлж 7 жил буюу 84 сар болгосон нь иргэдийн гар дээр ирэх тэтгэврийн дүн багасаж байгаа юм.

Иргэдэд олгож байгаа тэтгэвэр нь тухайн даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацаа болон шимтгэл төлсөн дундаж цалин хөлснөөс шууд хамааралтайгаар бодогддог.

Хуулийн төсөл тэтгэвэр тогтоолгох хөдөлмөрийн хөлсийг даатгуулагч тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх аль дуртай дараалсан 5 жилд төлсөн шимтгэлээс тооцож гаргасан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос бодож тодорхойлох зорилготой.

Иргэдийн өндөр насны тэтгэврийн гар дээр авах мөнгө дүн бодитоор нэмэгдэнэ. Иргэд өөрсдийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэлээс өндөр насны тэтгэврээ авч байгаа учир улсад төсөв, эдийн засгийн эрсдэл, хүндрэл учрахгүй.

Хуулийн төсөл Үндсэн хууль болон бусад хуульд нийцэж байгаа бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт орохгүй, дагалдан хууль батлахгүй.

--- оОо ---

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын...-ны өдөр

Улаанбаатар
хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх заалтын “долоон жилд” гэснийг “таван жилд” гэж, мөн зүйл, заалтын 1/ дэх хэсгийн “долоон жилийн” гэснийг “таван жилийн” гэж, мөн зүйл, заалтын 2/ дахь хэсгийн “долоон жилийн” гэснийг “таван жилийн” гэж, мөн зүйлийн 2 дахь заалтын “долоон жилээс” гэснийг “таван жилээс” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ,
ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН**

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсад үйлчилж байгаа нийгмийн хамгааллын бодлого шинэчлэн өөрчлөгдсөөр байгаа хэдий боловч зорилтод бүлгийн иргэдийн амьдралын наад захын хэрэгцээг хангахуйц бус, дутагдалтай байсаар байна. Үүний нэг илрэл нь өндөр насны тэтгэвэр тогтоохдоо иргэдийн ажилласан 7 жилийн дунджаар тооцож байгаа нь байдал нь шударга, энэрэнгүй зарчимд суурилдаг манай улсын тэтгэврийн тогтолцоонд нийцэхгүй байна.

Засгийн газар ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, олон хүүхэд төрүүлж өсгөж байгаа эхчүүд, хүүхдүүд, иргэдэд хандсан олон арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа. Гэхдээ Нийгмийн хамгааллын бодлого тухайн зорилтод бүлэгтээ үр өгөөжтэй, хүртээмжтэй байх, цаашлаад дэлхий жишигт нийцүүлэн шинэчлэх асуудлыг үргэлжлүүлэн Улсын Их Хурлаас батлан гаргах зайлшгүй шаардлагатай байна.

Монгол Улсын төрөөс хүн амын нийгмийн хамгааллыг сайжруулах бодлогыг тодорхойлж нийгмийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгон улс орныхоо онцлогт нийцсэн тэтгэврийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2015-2030 онд баримтлах үндсэн чиглэлд “2.1.1.Монгол Улсын ахмад настан бүр орлогын наад захын баталгаат тэтгэврээр хангагдах;”, “3.2.16.тэтгэврийн хэмжээг жил бүрийн үнийн өсөлт болон дундаж цалин хөлсний өсөлттэй уялдуулан нэмэгдүүлж, шаардагдах хөрөнгийг төсөвт тусгаж байх;”-аар, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.5-д “Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг инфляц, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ” гэж тус тус заасан.

2018 оны 2 дугаар сарын 2-ны өдөр Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулахдаа өндөр насны тэтгэврийг дараалсан 7 жилийн буюу 84 сарын дундаж цалингаар тогтоохоор өөрчилсөн. Энэхүү өөрчлөлтөө тайлбарлахдаа ийнхүү 7 жилийн дунджаас тэтгэврийн дунджийг бодож тогтоовол өндөр тогтоно, олон жил шимтгэл төлснөөр авах тэтгэврийн хэмжээ нь нэмэгдэх буруу ойлголт, үйл ажиллагааг засаж, залруулах зайлшгүй шаардлагатай байна.

**УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, А.Адъяасүрэн нарын санаачлан боловсруулсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу судалсан болно.

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль болон олон улсын гэрээнд харшлаагүй нийцэж байна.

Төрөөс тэтгэврийн тогтолцооны асуудлыг зөв тодорхойлох, нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлалыг бий болгох, шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд зарим арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа хэдий ч төрөөс зайлшгүй зохицуулах шаардлагатай зарим асуудал байсаар байна.

Тэтгэврийн даатгалын тогтолцоонд тэтгэвэрт гарч байгаа иргэдийн насны бүтэц, дундаж наслалтын хэтийн төлөвийг харгалзан үзэх хэдий ч Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "... хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, ... иргэнийхээ өмнө Төр хариуцна." гэж заасны дагуу цаашид тэтгэврийн даатгалын шимтгэлийн хэмжээ, хуримтлалын тогтолцоог өөрчлөх бодлого барьж ажиллах хэрэгцээ шаардлага байна.

2018 оны 2 дугаар сарын 2-ны өдөр Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулахдаа өндөр насны тэтгэврийг дараалсан 7 жилийн буюу 84 сарын дундаж цалингаар тогтоохоор өөрчилсөн. Энэхүү өөрчлөлтөө тайлбарлахдаа ийнхүү 7 жилийн дунджаас тэтгэврийн дунджийг бодож тогтоовол өндөр тогтоно, олон жил шимтгэл төлснөөр авах тэтгэврийн хэмжээ нь нэмэгдэнэ гэж буруу тайлбарлаж байна.

Өнөөдөр манай улсад дунджаар 317 мянга орчим нь өндөр насны тэтгэвэр авагч байдаг. 2017 онд тэтгэврийн насыг нэмэгдүүлсэн, 2018 онд өндөр насны тэтгэвэр тогтоохдоо нийгмийн даатгалын шимтгэл тасралтгүй төлсөн 5 жилийн буюу 60 сарын дундаж цалингаар тогтоодог байсныг нэмэгдүүлж 7 жил буюу 84 сар болгосон нь иргэдийн гар дээр ирэх тэтгэврийн дүн багасаж байгаа юм.

Хуулийн төслийг боловсруулах зорилго нь Монгол Улсын иргэний Үндсэн хуульд заасан эрхийг бүрэн эдлүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, Нийгмийн хамгааллын тогтолцоог сайжруулах, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэгт оршино.

ХОЁР.АСУУДЛЫГ ҮҮСГЭЖ БУЙ УЧИР ШАЛТГААН

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно", Арван есдүгээр зүйлийн нэг дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж тус тус заасан нь төр иргэддээ шударга, энэрэнгүй бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэйг баталж байна.

2018 онд өндөр насны тэтгэвэр тогтоохдоо нийгмийн даатгалын шимтгэл тасралтгүй төлсөн 5 жилийн буюу 60 сарын дундаж цалингаар тогтоодог байсныг нэмэгдүүлж 7 жил буюу 84 сар болгосон нь иргэдийн гар дээр ирэх тэтгэврийн дүн багасаж байгаа юм. Тиймээс иргэд насаараа хөдөлмөрлөж төлсөн нийгмийн даатгалын шимтгэлээсээ бодитоор тооцуулж тэтгэврээ шударгаар тогтоолгох ёстой.

ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Хүний амьдралд өөрөөс нь хамаарахгүйгээр өвдөх, осолдох, эндэх гэх зэрэг олон эрсдэл тохиолддог. Иргэдийн амьдралд тохиолдох эрсдэлүүд хэзээ, хэдийд тохиолдохыг хэн ч урьдчилан тааж мэдэх боломжгүй юм. Тэгэхээр нийгмийн даатгалд даатгуулснаар өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, ажилгүй болох, өвчлөх, үйлдвэрлэлийн осолд өртөх зэрэг урьдчилан таах боломжгүй эрсдэлийн улмаас орлого олох чадвар буурах, орлогогүй болох үедээ тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрхтэй болдог.

Өнөөдөр манай улсад дунджаар 317 мянга орчим нь өндөр насны тэтгэвэр авагч байдаг. 2017 онд тэтгэврийн насыг нэмэгдүүлсэн, 2018 онд өндөр насны тэтгэвэр тогтоохдоо нийгмийн даатгалын шимтгэл тасралтгүй төлсөн 5 жилийн буюу 60 сарын дундаж цалингаар тогтоодог байсныг нэмэгдүүлж 7 жил буюу 84 сар болгосон нь иргэдийн гар дээр ирэх тэтгэврийн дүн багасаж байгаа юм.

Иргэдэд олгож байгаа тэтгэвэр нь тухайн даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацаа болон шимтгэл төлсөн дундаж цалин хөлснөөс шууд хамааралтайгаар бодогддог. Тиймээс иргэд тэтгэврээ шударгаар тогтоолгох эрхтэй.

ДӨРӨВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.1-т заасан зохицуулалтын хувилбарын дагуу асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, эерэг болон сөрөг талыг нь харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа:

	Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа
1	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн иргэн энэ хуульд хамрагдана.	Хуульд заасан шаардлага хангасан нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагчийн өндөр насны тэтгэвэг тогтоолгохдоо 7 жилийн дунжийг 5 жил болгоно.
2	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Иргэд өөрсдийн төлсөн шимтгэлээсээ шударгаар тэтгэврээ тогтоолгоно	Тэтгэвэр тогтоолгогч иргэн өөрийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн өгөөжөө хүртэнэ.

**ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ
ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ**

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар	
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм		Шударга ёсны зарчимд нийцсэн
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм		Шударга ёсны зарчимд нийцнэ
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм		Шударга, тэгш, эерэг үр дүнтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын	Тийм		Шударга, тэгш, эерэг үр дүнтэй

	олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх			байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх		Үгүй	энэ асуудалтай холбогдолгүй
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх		Үгүй	Хуулийн зорилго, шударга ёсонд нийцсэн
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх		Үгүй	Шаардлагагүй
3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх			
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	болгох эсэх			
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Зардал гарахгүй
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн шинэ чиг үүрэг үүсгэхгүй
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй. Олон улсын гэрээ,

				хэлэлцээртэй нийцнэ.
--	--	--	--	-------------------------

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх явц сайжирч, зэрэг нөлөө гарна.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй

-----oOo-----

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, А.Адъяасүрэн нарын санаачлан боловсруулсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн /цаашид “Хуулийн төсөл” гэх/ зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад зөвлөмж өгөх зорилгоор хийлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь хэсэгт заасан хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл хэлбэрээр боловсруулагдсан хувилбар байв. Хуулийн төсөл нь 2 зүйлээс бүрдэж байна.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”¹-д /цаашид “аргачлал” гэх/ заасны дагуу хийлээ.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу судалсан болно.

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль болон олон улсын гэрээнд харшлаагүй нийцэж байна.

2018 оны 2 дугаар сарын 2-ны өдөр Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулахдаа өндөр насны тэтгэврийг дараалсан 7 жилийн буюу 84 сарын дундаж цалингаар тогтоохоор өөрчилсөн. Энэхүү өөрчлөлтөө тайлбарлахдаа ийнхүү 7 жилийн дунджаас тэтгэврийн дунджийг бодож тогтоовол өндөр тогтоно, олон жил шимтгэл төлснөөр авах тэтгэврийн хэмжээ нь нэмэгдэнэ гэж буруу тайлбарлаж байна.

Өнөөдөр манай улсад дунджаар 317 мянга орчим нь өндөр насны тэтгэвэр авагч байдаг. 2017 онд тэтгэврийн насыг нэмэгдүүлсэн, 2018 онд өндөр насны тэтгэвэр тогтоохдоо нийгмийн даатгалын шимтгэл тасралтгүй төлсөн 5 жилийн буюу 60 сарын дундаж цалингаар тогтоодог байсныг нэмэгдүүлж 7 жил буюу 84 сар болгосон нь иргэдийн гар дээр ирэх тэтгэврийн дүн багасаж байгаа юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “... хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, ... иргэнийхээ өмнө Төр хариуцна.” гэж заасны дагуу иргэд өөрсдийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл төлж тэтгэвэр тогтоолгохдоо өөрт аль ашигтай, шударгаар тэтгэврээ тогтоолгох бодлого барьж ажиллах хэрэгцээ шаардлага байна.

Хуулийн төслийг боловсруулах зорилго нь Монгол Улсын иргэний Үндсэн хуульд заасан эрхийг бүрэн эдлүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны

¹Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

ашиг сонирхлыг хамгаалах, Нийгмийн хамгааллын тогтолцоог сайжруулах, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэгт оршино.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд заасны дагуу 6 шалгуур үзүүлэлтээс 3 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Ойлгомжтой байдал
3. Харилцан уялдаа зэрэг болно.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгов.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл тул түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд болон хэл зүй, найруулгын хувьд ойлгомжтой боловсруулагдсан эсэхийг Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-д заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах үүднээс үнэлэхийг зорьж сонголоо.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь хуульд нэмэлт оруулах төсөл тул хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд болон хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо нийцсэн эсэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг шалган тогтоож, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулах үүднээс хуулийн төслийг бүхэлд нь Аргачлалын 4.10-т заасан стандарт асуултуудад хариулах замаар үнэлэхээр сонгосон болно.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийв.

Хуулийн төслийг боловсруулахдаа нийгмийн даатгалын шимтгэл төлж өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх нь нээгдсэн иргэн тэтгэврээ шударгаар тогтоолгоход хуулийн зорилго оршиж байна.

Иймд энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн заасанд үнэлгээ хийхээр сонгож авлаа.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа.

/Хуулийн төсөл 2 зүйлтэй./

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгах үүднээс хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

/Хуулийн төсөл 2 зүйлтэй./

ДӨРӨВ.УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараахь байдлаар авч үзэв.

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 1 дүгээр зүйл	Зорилгод дүн шинжилгээ хийх
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг шалгах байдлаар <u>ойлгомжтой</u> байдлыг шалгах.
3	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Аргачлалын 4.10-т заасан стандарт асуултад

			хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог шалгах
--	--	--	---

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараахь байдлаар үнэллээ.

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хуулийн төслийн үзэл баримтлалаас харахад өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн иргэн энэ хуулийн үйлчлэлд хамаарна.

Үнэлгээ хийхээр сонгож авсан зохицуулалтын хувьд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагад нийцэж, хуулийн төслийн зорилтыг хангах боломжтой байна.

Хэдийгээр төр засгаас тодорхой арга хэмжээ авч ирсэн боловч одоо буруу бодлого хэрэгжүүлж байна. Өөрөөр хэлбэл тэтгэвэр тогтоолгох эрх нь үүссэн иргэн ажилласан өөрийн сонгох 5 жилийн буюу 60 сарын дунджаар тогтоолгодог байсныг 2018 оны 2 дугаар сарын 2-ны өдөр хуульд өөрчлөлт оруулж 7 жил буюу 84 сар болгосон нь олон сарын дундаж өндөр гарна гэж харагдаж байгаа ч бодит тооцооллоор хуучин тогтоодог байснаас бага тэтгэвэр тогтохоор байна.

Иймд хуулийн төслөөр тэтгэврийг тогтоохдоо бодитоор шударгаар 8 иргэнээ бодсон, иргэний талд үйлчлэхээр байгаа явдал нь дэвшилттэй бөгөөд зорилгодоо хүрнэ.

“Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
<i>Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт</i>	<i>Шаардлага хангасан эсэх</i>
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Шаардлага хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн	Шаардлага хангасан.

харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Зөрчилгүй.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлага хангасан.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Шаардлагагүй.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Шаардлагагүй.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Шаардлагагүй.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	

30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлага хангасан.
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан.
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан

“Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгахыг зорьлоо.

Д/д	Асуулт	Хариулт буюу дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Хуулийн төсөл нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоож олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
2	хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	Шаардлага хангасан.
3	хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Нийцэж байгаа.
5	хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Давхардсан зүйлгүй.
6	хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй.
7	хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй.
8	төрийн байгууллагын чиг	Үгүй.

	үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	
9	татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Хуулийн төсөлд татвар, төлбөр хураамжийн асуудал тусгагдаагүй.
10	тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Хуулийн төсөлд аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй.
11	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй.
12	хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Хуулийн төсөл нь жендерийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.
13	хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
14	хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
15	хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Хуулийн төсөлд хориглосон хэм хэмжээ тусгаагүй тул шаардлагагүй.

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

5.1.Баримтжуулалт

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд ашигласан дараах баримт бичиг, мэдээлэл, тоо баримтыг цуглуулан үр нөлөөг тооцох ажиллагааны тайланд баримтжуулж хавсаргалаа.

1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль;
2. Өндөр насны тэтгэвэр тогтоох аргачлал;
3. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авч буй иргэдийн судалгаа;

5.2.Дүгнэлт

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг уг хуулийн бусад зохицуулалтууд хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон эсэхэд үнэлгээ хийсэн.

Хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлүүдийн хувьд хуулийн төслийн үзэл баримтлал болон энэхүү хуулийг төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлагатай нийцэж байгаа нь зорилгод хүрэх, ойлгомжтой байх, бусад хууль тогтоомжтой нийцсэн, давхардалгүй, зөрчилгүй томъёологдсон байна.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ СУДАЛГАА

"Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлалын дагуу хийлээ.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход доор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан болно:

- гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

Нэг. Хуулийн этгээдийн зардал

1. Аргачлалд заасны дагуу уг зардлыг тооцохдоо дараах үе шатаар зохион байгуулсан:

- 1.1. Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 1.2. Зардлыг тооцох;
- 1.3. Тоон үзүүлэлтийг тооцох;
- 1.4. Нийт зардлын дүнг тооцож гаргах;
- 1.5. Хялбарчлах боломжийг шалгах;
- 1.6. Нэмэлт зардлыг тооцох.

Аргачлалын 2.3-т хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоохдоо хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэг нэг бүрийг тогтоохоор дурдсан байна.

Гүйцэтгэх үүрэг гэдгийг тухайн хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах хуульд заасны дагуу тоо баримт, тайлан, холбогдох бусад мэдээллийг бэлтгэн төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд гаргаж өгөх, эсхүл хүргүүлэхийг ойлгохоор тусгажээ. /Үүнд бүх төрлийн өргөдөл, хүсэлт, маягт бөглөх, статистик тоо мэдээ өгөх, бүртгүүлэх, нөхөн олговор, төрөөс тусламж, дэмжлэг, зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл гаргах, зөвшөөрөл хүсэх гэх мэт үүрэг хамаарна./

Аргачлалд зардлыг тооцохын тулд ажилтны ажлын хөлс, мэдээлэл бэлтгэн гаргахтай холбогдуулан хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүний гүйцэтгэлийн хугацааг нэг бүрчлэн тодорхойлох шаардлагатай:

Тус хуулийн 3.1.1-д заасан "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай" хуулийн төсөлтэй холбогдуулан зардлын тооцоо гаргавал:

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд нэмэлт зардал гарахгүй бөгөөд, төрийн албан хаагчдын хувьд орон тоо нэмэгдэхгүй, ажлын үүргийн давхардал, чиг үүрэг өөрчлөгдөх зүйлгүй, улсын төсөвт хүндрэл учрахгүй, улсын төсвийн орлого, зарлагад нөлөөлөхгүй, аливаа эрсдэл учрахгүй болно.

Хуулийн төслөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн иргэний өндөр насны тэтгэврийг тооцоолохдоо удирдлага болгох заалтыг зохицуулахаар тусгасан байна.

-----oOo-----



Хаагдсан



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Байнгын хороогоор төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх	Нэгдсэн хуралдаанаар төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх	Байнгын хорооны анхны хэлэлцүүлэг	Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэг	Байнгын хорооны эцсийн хэлэлцүүлэг	Нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэг
--	---	-----------------------------------	--------------------------------------	------------------------------------	---------------------------------------

Төслийн файлыг татах

Share 0



Tweet

ТӨСЛИЙН ХАВСРАЛТУУД

1. Үзэл баримтлал
2. Танилцуулга
3. Судалгаа, лавлагаа, тооцоо, бусад мэдээлэл

ТӨСӨЛ САНААЧЛАГЧИД

ПҮРЭВДОРЖ БӨХЧУЛУУНЫ

дагасан (0)



үзсэн (122)



санал (0)

Нийтэлсэн : Хэлэлцүүлгийн Хөтөч

Огноо : 2020-12-16

Та санал өгөхийн тулд нэвтрэх шаардлагатай!

САНАЛ АСУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд саналаа өгнэ үү?

ДЭМЖИНЭ

65%

ДЭМЖИХГҮЙ

30%

МЭДЭХГҮЙ

3%

Санал өгөх

Идэвхитэй

Эргэлтэй

> Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн Төсөл

> Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга

> Цагдаагийн албаны тухай

> Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай / Шинэчилсэн найруулга/

> ХОТ-ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН БАЙЛЛЫН